



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/523

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.22, 1.3.4.1 дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Ховдын хөгжил-2019" үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад болон "Ховд брэнд" бүтээгдэхүүнээр шалгарсан бүтээгдэхүүнд олгох шагналд шаардагдах зардлын төсөв 5920000 мянган төгрөг /Таван сая есөн зуун хорин мянга/ -ийг хавсралтаар баталж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт Орон нутгийн хөгжлийн сангийн 5.34-д заасан Ховдын брэнд бүтээгдэхүүн арга хэмжээний санхүүжилтээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 02608

D/Zah-A/523-Da

Аймгийн Засаг даргын 2019 оны
08 дугаар сарын 13-ны өдрийн
А/523 дугаар захирамжийн
хавсралт

“ХОВДЫН ХӨГЖИЛ-2019” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Үзэсгэлэн худалдаанд шаардагдах зүйлсийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1.	Үзэсгэлэн худалдаанд оролцогчдыг бүртгэн мандат олгох	ш	150	2000	300.000
2.	Мандатны уут	ш	150	300	45.000
3.	Өргөмжлөл	ш	17	65000	1105000
4.	Цом	ш	17	60000	1020000
5.	Брэнд бүтээгдэхүүний гэрчилгээ /жаазны хамт /	ш	3	75000	225000
6.	Брэнд бүтээгдэхүүнд олгох хэвлэмэл лого	ш	3	30000	90000
7.	Мөнгөн шагнал, батламжийн хамт	ш	3	1.045000	3135000
	Дүн				5920000